МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 15

ЦАХИМ ОРЧИНД МӨРИЙТЭЙ ТОГЛООМ ЗОХИОН БАЙГУУЛСАН 8 ИРГЭН ЯЛ ШИЙТГЭГДЖЭЭ


МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот


ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

5.7 дугаар зүйл. Мөрийтэй тоглоом тоглох

1.Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом тоглосон бол ЗӨРЧИЛ ҮЙЛДЭХЭД АШИГЛАСАН ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГСЭЛ, ХУУЛЬ БУСААР ОЛСОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ ХУРААЖ ХҮНИЙГ 1000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

www.prokuror.mn

Баянгол дүүргийн прокурорын газар болон тус дүүргийн Цагдаагийн газраас цахим орчинд мөрийтэй тоглоом зохион байгуулах хууль бус үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хэд хэдэн ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд 2021 оны эхний улирлын байдлаар тус дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цахим орчинд лотто, покер зэрэг бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулсан гэмт хэргийн талаарх 33 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж, 4 хэргийн 8 хүнд холбогдох хэргийг шүүхээр шийдвэрлүүлжээ.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

20.17 дугаар зүйл. Мөрийтэй тоглоом зохион байгуулах

1.Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол 45.000-14.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 240 ЦАГААС 720 ЦАГ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ, ЭСХҮЛ 6 САРААС 3 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ, ЭСХҮЛ 6 САРААС 3 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ХОРИХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

2.Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол 5.400.000-27.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 1 ЖИЛЭЭС 5 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ, ЭСХҮЛ 1 ЖИЛЭЭС 5 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ХОРИХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

www.prokuror.mn

Тус дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүгдэгч нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэж, хууль бусаар олсон орлого болох 7.050.000 төгрөг болон гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан техник хэрэгслийг улсын орлого болгосон байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2848